



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН УЛСЫН ХОРОО

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН СТАТИСТИКИЙН ЭМХЭТГЭЛ

Statistical year book of sport

2025



УЛААНБААТАР ХОТ
2026 ОН



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ БИЕЙН
ТАМИР СПОРТЫН УЛСЫН ХОРОО

НЭГДСЭН ТАЙЛАН 2025

УЛААНБААТАР ХОТ
2026 ОН

Эмхэтгэлийг хянасан:

Э.Билэгт

О.Гэрэл

Мэдээг бэлтгэсэн:

Аймаг, нийслэл, дүүргийн БТСГ, хороодын статистик хариуцсан мэргэжилтнүүд

Мэдээг нэгтгэн боловсруулсан:

Б.Ганзориг

Газрын зургийг ArcGIS программ

ашиглан зураглав:

Ч.Цогзолмаа /Бизнесийн удирдлагын мастер, Японы Олон Улсын Их сургууль, Япон Улс/

Холбоо барих хаяг:

ЗГХА-Биеийн тамир, спортын улсын хороо.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо Бага тойруу-55, Спортын төв ордон

www.sport.gov.mn

<https://sport.gov.mn/statistics>

info@sport.gov.mn

Утас: 263696

Факс: 325234

© Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг- Биеийн тамир, Спортын Улсын Хороо

АГУУЛГА

1. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД.....	7
2. ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРСОН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАРИЛГА, ГАДАА ТАЛБАЙ.....	14
2.1. Спортын барилга байгууламж	14
2.2. Спортын гадаа талбай.....	16
3. ШИНЭЭР ЦОЛ АВСАН ТАМИРЧИД, ШҮҮГЧИД, ҮНДЭСНИЙ БӨХ, УЯАЧИД, ХАРВААЧИД, ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХЭД.....	18
3.1 Шинээр цол авсан тамирчид	18
3.2. Цолтой шүүгчид	21
3.3. Үндэсний бөх	24
3.4. Цолтой сурын харваач	26
3.5. Цолтой уяач.....	28
3.6. Хурдан морь унаач хүүхэд.....	30
4. БИЕ БЯЛДРЫН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛД ХАМРАГДАГЧИД.....	33
5. СПОРТЫН ТАМИРЧИД	38
6. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ	41
7. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОГЧИД	47
8. ХАВСРАЛТ.....	54

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:

ЗГТА –Засгийн газрын тохируулагч агентлаг

БТСУХ- Биеийн тамир, спортын улсын хороо

ҮСХ- Үндэсний статистикийн хороо

БТСГ- Биеийн тамир, спортын газар

БТСХ-Биеийн тамир, спортын хороо

ЗСМ- Захиргааны статистик мэдээ

АСМ- Албаны статистик мэдээ

БТС- Биеийн тамир, спорт

ӨМНӨХ ҮГ



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хорооноос салбарын статистик тайлан мэдээ болох “Биеийн тамир, спортын статистикийн эмхэтгэл-2025”-ыг та бүхэнд хүргэж байна. Салбарын статистик мэдээг сайжруулах, бодлого боловсруулахад ашиглах, өгөгдлийн сан бүрдүүлэх чиглэлд 2017 оноос авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд Биеийн тамир, спортын салбар 3 жилийн голлох үндсэн үзүүлэлтийн динамик өөрчлөлтийг харуулсан эмхэтгэлийг найм дахь жилдээ гаргаж байна.

“Биеийн тамир, спортын статистикийн эмхэтгэл-2025”-д тусгагдсан статистикийн мэдээ нь Үндэсний статистикийн хороо хүлээн зөвшөөрч, албан ёсны маягтаар баталгаажсан тоо баримт бөгөөд эрхэм таны ажлын хэрэгцээг хангахуйц үнэ цэнтэй суурь мэдээлэл болно гэдэгт найдаж байна.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.БИЛЭГТ

1. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИД

Монгол Улсад 2025 онд биеийн тамир, спортын нийт 35 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 2-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

ГРАФИК 1. Үйл ажиллагаа явуулж буй биеийн тамир, спортын байгууллага, бүсээр



Үйл ажиллагаа явуулж буй биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж буй ажиллагчид 2025 онд улсын хэмжээнд нийт 900 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 48 буюу 5.1%-р буурсан байна. Нийт ажиллагчдын¹ 263 (29.2%) нь нийслэлд, 191 (21.2%) нь Хангайн бүсэд, 222 (24.7%) нь Төвийн бүсэд, 121 (13.4%) нь Баруун бүсэд байгаа бол 103 (11.4%) нь Зүүн бүсэд байна.



ГРАФИК 2. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, бүсээр




Ажиллагчдын тоог аймаг, нийслэлээр авч үзвэл, 263 (29.2%) нь Улаанбаатарт, 65 (7.2%) нь Сэлэнгэ аймагт, 43 (4.8%) нь Сүхбаатар аймагт, 42 (4.7%) нь Дорноговь аймагт байгаа нь тус бүр хамгийн өндөр дүнтэй байна. Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Өмнөговь, Төв болон Увс, Ховд аймгуудын ажиллагчдын тоо өмнөх онтой харьцуулахад өөрчлөлтгүй, харин Дархан-уул, Дорноговь болон Хөвсгөл аймгуудын ажилчдын тоо нэмэгдэж, бусад аймгуудын ажиллагчдын тоо буурсан үзүүлэлттэй байна.

¹ Тайлант оны мэдээ бэлтгэхдээ суманд ажиллаж буй биеийн тамирын арга зүйч нарын тоог оруулсан болно.

ЗУРАГ 1. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, аймаг, нийслэл, хүйсээр






Улсын дунджаар биеийн тамир, спортын 1 ажилтанд биеийн тамир, спортоор зонхилон хичээллэдэг 6 – 64 насны хүн ам 2023, 2024 онуудад тус бүр 3158, 3076 байсан бол 2025 онд 2615 болсон байна. Харин спортын ажилтан буюу албан тушаалын хувьд мэргэжилтэн, дасгалжуулагч, биеийн тамирын арга зүйч, эмч нараас бүрдсэн 1 ажилтан тутамд 2024 онд 6828 хүн ногдож байсан бол 2025 онд 6081 хүн ногдож байна.

ХҮСНЭГТ 1. Ажиллагчид, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	Биеийн тамир, спортын байгууллага	Ажиллагчид		Нэг ажилтанд ногдох хүн		Спортын нэг ажилтанд ногдох хүн ам		Спортын нэг ажилтанд ногдох хүн ам
		- Бүгд	ам 2023	ам 2024	ам 2025			
Бүгд	35	900	3158	6724	3076	6828	3230	7074
Баруун бүс	5	121	2761	5998	2804	5746	2858	6650
Баян-Өлгий	1	29	3949	12976	3183	6153	3129	6050
Говь-Алтай	1	15	2424	6060	2687	8061	3189	7972
Завхан	1	22	2899	7609	2640	6746	2711	6628
Увс	1	29	1841	2872	2485	4239	2464	8931
Ховд	1	26	3300	7591	2964	5505	2928	5437
Хангайн бүс	7	191	2340	5580	2394	6070	2642	6469
Архангай	1	41	2140	6599	1838	4390	1887	3868
Баянхонгор	1	33	1115	1738	1445	3130	2268	4679
Булган	1	23	1957	7270	2204	7243	2161	7100
Орхон	1	26	2972	9908	3352	8227	3479	8224
Өвөрхангай	2	34	2864	8853	2714	7516	2838	7423
Хөвсгөл	1	34	5064	12940	3652	10625	3403	10517
Төвийн бүс	8	222	2098	4698	2127	4816	1989	4015
Говьсүмбэр	1	23	664	1174	676	1196	670	1186
Дархан-Уул	1	28	3773	7889	3269	6304	3169	5916
Дорноговь	1	42	1563	4689	2460	8784	1519	2658
Дундговь	1	15	2552	5468	2568	5503	2557	4794
Өмнөговь	1	24	2565	4008	2793	5586	2854	5707
Сэлэнгэ	2	65	1602	4722	1343	3462	1359	3397
Төв	1	25	3083	5929	3095	6448	3140	6542
Зүүн бүс	3	103	2319	6016	1778	4037	1882	4124
Дорнод	1	21	3559	8897	3403	8933	3389	8896
Сүхбаатар	1	43	1451	3243	1182	3268	1305	3507
Хэнтий	1	39	2648	9457	1628	2902	1706	2892
Улаанбаатар	12	263	5033	9046	4825	9953	5405	11464


Нийт ажиллагчдыг хүйсээр авч үзэхэд улсын хэмжээнд нийт 900 ажиллагчид байгаагийн 398 (44.2%) нь эмэгтэй, 502 (55.8%) нь эрэгтэй ажиллагчид байна.

ГРАФИК 3. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, хүйсээр, аймаг, нийслэлээр




Нийт ажиллагчдыг албан тушаалаар авч үзвэл, нийт ажиллагчдын 302 (33.2%) нь үйлчилгээ, аж ахуйн ажилтан, 162 (18.0%) нь мэргэжилтэн, 151 (16.8%) нь дасгалжуулагч, 101 (11.2%) нь захиргаа болон санхүүгийн ажилтан, 56 (6.2%) нь удирдах албан тушаалын ажиллагчид байна. Харин 128 (14.2%) нь биеийн тамирын арга зүйч, эмч болон бусад албан тушаалын ажиллагчид байна.

ГРАФИК 4. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, албан тушаалаар




Нийт ажиллагчдын албан тушаалыг бүсээр авч үзвэл, Улаанбаатар, Хангайн болон Төвийн бүсүүдэд үйлчилгээ, аж ахуйн ажилтан давамгайл байна. Үүнээс гадна хамгийн олон мэргэжилтэн нийслэлд ажиллаж байна.

ГРАФИК 5. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, албан тушаалаар, бүсээр



Хамгийн олон тооны буюу үйлчилгээ, аж ахуйн ажилтны тоог аймгуудаар авч үзвэл нийт 302 ажилтан байгаагаас хамгийн олон буюу Сэлэнгэ аймагт 33, Сүхбаатар аймагт 23, Өвөрхангай аймагт 15 тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 2. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчид, албан тушаалаар, аймаг, нийслэлээр, 2025 он



Дасгалжуулагч болон биеийн тамирын арга зүйч нь энэ салбарт өндөр ач холбогдол бүхий мэргэжил юм. Тус 2 мэргэжлийн статистикийг аймаг, нийслэлээр авч үзвэл, Улаанбаатар болон Хэнтий аймагт тус бүр 15 дасгалжуулагч, мөн Дорноговь аймагт 17 дасгалжуулагч, Сэлэнгэ аймагт 13 арга зүйч байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

ГРАФИК 6. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж буй дасгалжуулагч, аймаг, нийслэлээр





ГРАФИК 7. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллаж биеийн тамирын арга зүйч, аймаг, нийслэлээр



2. ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРСОН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАРИЛГА, ГАДАА ТАЛБАЙ

2.1. Спортын барилга байгууламж


Монгол Улсад 2025 онд биеийн тамир, спортын 43 спорт заал ашиглалтад орж нийт заалны тоо 1559 болсон байна. 2024 оны Биеийн тамир, спортын улсын II тооллогоор нийт 1516 спорт заал тоологдсоноос хойш тайлангийн хугацаанд 2.8%-иар нэмэгдсэн байна. Биеийн тамир, спортын барилга нь хэд хэдэн төрлөөс бүрдэх бөгөөд нийт тооны дийлэнх хувийг “спорт заал” эзэлж байгааг доор зургаас харах боломжтой. Хэвийн үйл ажиллагаа явуулж буй 1559 спортын барилга байгууламжийн 1356 (73.1%) нь “спорт заал” төрөлд хамаарч байна.

ЗУРАГ 3. Спортын барилга, өссөн дүнгээр




* 2024 оны суурь дүнг “Биеийн тамир спортын улсын тооллого-2024”-ээр авав.

ГРАФИК 8. Спортын барилга, дүнд эзлэх хувиар.




ЗУРАГ 4. Спорт заал, аймаг, нийслэлээр, 2025



ХҮСНЭГТ 2. Спорт заал, дүүргээр, өссөн дүнгээр, 2025

Улаанбаатар	371
Багануур	10
Багахангай	5
Баянгол	57
Баянзүрх	58
Налайх	17
Сонгинохайрхан	47
Сүхбаатар	58
Хан-Уул	81
Чингэлтэй	38

ГРАФИК 9. Биеийн тамир, спортын барилга, бүсээр



2.2. Спортын гадаа талбай


Биеийн тамир, спортын зориулалт бүхий 84 гадаа талбай 2025 онд ашиглалтад орж нийт гадаа талбайн тоо 2063 болсон байна. Биеийн тамир, спортын улсын II тооллогоор 1979 гадаа талбай тоологдсоноос хойш тайлангийн хугацаанд нийт 4.2%-р нэмэгдсэн байна.

ЗУРАГ 5. Спортын гадаа талбай, өссөн дүнгээр




* 2024 оны суурь дүнг “Биеийн тамир спортын улсын тооллого-2024”-ээр авав.

ГРАФИК 10. Шинээр ашиглалтад орсон биеийн тамир, спортын гадаа талбай, бүсээр



ЗУРАГ 6. Спортын гадаа талбай, аймаг, нийслэлээр, 2025



ХҮСНЭГТ 3. Спортын гадаа талбай, дүүргээр, өссөн дүнгээр, 2025

Улаанбаатар	246
Багануур	9
Багахангай	26
Баянгол	21
Баянзүрх	32
Налайх	28
Сонгинохайрхан	17
Сүхбаатар	28
Хан-Уул	42
Чингэлтэй	43


2025 онд шинээр ашиглалтад орсон талбайн 23 (27.4%) нь Төв, 19 (22.6%) нь Баруун бүсэд, 16 (19.0%) нь Хангайн бүсэд, 15 (17.9%) нь Улаанбаатарт, 11 (13.1%) нь Зүүн бүсэд байршилтай байна.

3. ШИНЭЭР ЦОЛ АВСАН ТАМИРЧИД, ШҮҮГЧИД, ҮНДЭСНИЙ БӨХ, УЯАЧИД, ХАРВААЧИД, ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХЭД

3.1 Шинээр цол авсан тамирчид


Монгол Улсад 2025 онд нийт 2229 тамирчид спортын цол авсан байна. Үүнээс 1772 (79.5%) нь эрэгтэй, 457 (20.5%) нь эмэгтэй тамирчид байна.

ГРАФИК 11. Шинээр цол авсан тамирчид, хүйсээр





Шинээр цол авсан тамирчдыг бүсээр авч үзвэл нийслэлд 732 (32.8%), Хангайн бүсэд 614 (27.5%), Баруун бүсэд 395 (17.7%), Төвийн бүсэд 301 (13.5%) нь харин Зүүн бүсэд 187 (8.4%), цолтой тамирчид байна.


ГРАФИК 12. Шинээр цол авсан тамирчид, бүсээр



Цол авсан тамирчдыг аймгаар авч үзвэл Орхон аймагт 332, Ховд 116, Говь-Алтай 104, Архангай 75 бүртгэгдсэн нь нийслэлээс дараагаар орох өндөр үзүүлэлт бүхий аймгууд байна.


ЗУРАГ 6. Шинээр цол авсан тамирчид, аймаг, нийслэлээр






Тамирчдыг цолоор нь авч үзвэл, 696 (48.0%) нь спортын дэд мастер, 550 (38.0%) нь спортын мастер, 203 (14.0%) нь олон улсын хэмжээний мастер цолтой тамирчид байна.

ГРАФИК 13. Шинээр цол авсан тамирчид, цолоор



Цолтой тамирчдын дийлэнх хувийг бүрдүүлж буй спортын дэд мастер цолтой тамирчдыг бүсээр харвал нийслэлээс гадна Хангайн бүсэд тэргүүлж байна.


ГРАФИК 14. Шинээр цол авсан тамирчид, цолоор, бүсээр



2025 онд хамгийн олон бүртгэгдсэн спортын дэд мастер цолтой тамирчдыг аймаг, нийслэлээр авч үзвэл Орхон аймагт 150, Баянхонгор аймагт 32, Дорнод аймагт 25 спортын дэд мастер бүртгэгдсэн байна.



Үүний дараагаар Орхон аймагт 78, Дорнод аймагт 28, Говь-Алтай аймагт 25, Хэнтий аймагт 15 спортын мастер цолтой тамирчид бүртгэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

ЗУРАГ 7. Шинээр цол авсан тамирчид, цолоор, аймаг, нийслэлээр



2025


- Цолтой тамирчид
- 30 - 39
 - 40 - 49
 - 50 - 59
 - 60 - 99
 - 100 - 332
 - 732
- Цол
- ОУХМ
 - Мастер
 - Дэд мастер



3.2. Цолтой шүүгчид


Монгол Улсад 2025 онд олон улсын шүүгч 18, улсын цолтой шүүгч 75 бүртгэгдсэн байна. Нийт цолтой шүүгчдийн 72.0%-ийг эрэгтэй шүүгчид эзэлж байна. Мөн шинээр 2025 онд цол авсан шүүгчид нийслэл болон Хангайн болон Төвийн бүсэд давамгайл байна.

ГРАФИК 15. Цолтой шүүгчид, бүсээр



Сүүлийн жилүүдэд биеийн тамир, спортын арга хэмжээ эрс өсөлттэй зохион байгуулагдаж байгаа бөгөөд үүнийг дагаад цолтой тамирчид, шүүгчид нэмэгдэх хандлагатай байна. Шүүгчдийн улсын цолтой ба олон улсын цолтой гэж ангилдаг, тэгвэл уг ангиллаар нийслэл болон Хангайн, Төвийн бүсүүдэд хамгийн олон бүртгэгдсэн байна.


ГРАФИК 16. Цолтой шүүгчид, цолоор болон бүсээр



3.3. Үндэсний бөх


Монгол Улсад биеийн тамир спортын улсын тооллогоос хойш 2025 оны байдлаар өссөн дүнгээр улсын цолтой 454, аймгийн цолтой 2435, сумын цолтой 5273 бөхчүүд байна.

ГРАФИК 17. Үндэсний бөх, цол, өссөн дүнгээр



Улсын цолтой бөх өнгөрсөн онд Говь-Алтай, Завхан, Ховд, Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ аймгуудад тус бүр 1, Увс болон Төв аймгуудад тус бүр 2 нийт 10 бөхөөр нэмэгдэж байсан бол энэ онд Дорноговь аймагт 3, Говь-Алтай аймагт 2, Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Сэлэнгэ, Сүхбаатар болон Хэнтий аймгуудад тус бүр 1 нийт 11 улсын цолтой бөх нэмэгдсэн байна.

ЗУРАГ 8. Улсын цолтой бөх, аймаг, нийслэлээр, 2025 он




Энэ онд аймаг, сумын цолтой бөхчүүд өмнөх жилүүдийн өсөлттэй харьцуулахад аймгийн цолтой бөхчүүд нийслэлд 39, Увс аймагт 9, Говь-Алтай болон Завхан аймгуудад тус бүр 6, Орхон, Өвөрхангай болон Дундговь аймгуудад тус бүр 5 бүртгэгдэж улсын нэгдсэн тооллогоос хойш аймгийн цолтой нийт бөхчүүдийн тоо 2435 болсон байна. Эдгээрийн 326 (13.4%) нь Дорноговь аймагт бүртгэгдсэн нь хамгийн өндөр хувийг эзэлжээ.

ЗУРАГ 9. Аймгийн цолтой бөх, аймаг, нийслэлээр, 2025



Сумын цолтой бөхчүүд нийслэлд 58 нэмэгдсэнээс гадна Ховд аймагт 65, Увс аймагт 44, Завхан аймагт 40, Архангай болон Орхон аймгуудад тус бүр 32, бусад аймгуудад 2-25 бүртгэгдэж улсын нэгдсэн тооллогоос хойш сумын цолтой нийт бөхчүүдийн тоо 5273 болсон байна. Эдгээрээс 490 (9.3%) нь Дорнод аймагт бүртгэгдсэн нь хамгийн өндөр хувийг эзэлжээ.


ЗУРАГ 10. Сумын цолтой бөх, аймаг, нийслэлээр, 2025



3.4. Цолтой сурын харваач


Монгол Улсад 2025 оны байдлаар нийт 161 цолтой сурын харваачид бүртгэгдсэнийг бүсээр авч үзвэл, Хангайн бүсэд 34, Төвийн бүсэд 40, Зүүн бүсэд 36, Баруун бүсэд 44, нийслэлд 7 тус бүр бүртгэгдсэн байна.



ГРАФИК 18. Сурын харваач, бүсээр



Цолтой сурын харваачдыг аймаг, нийслэлээр авч үзвэл нийслэлд 7 бүртгэгдсэнээс гадна Хэнтий аймагт 21, Орхон аймагт 18, Дорноговь аймагт 16, Ховд аймагт 15 сур харваач бүртгэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлттэй аймгууд байсан бол бусад аймгуудад 10 орчим сур харваач бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 11. Сурын харваач, аймаг, нийслэлээр






3.5. Цолтой уяач


Монгол Улсын цолтой уяачдын тоо 2025 онд 566 бүртгэгдсэн бөгөөл үүнийг бүсээр харвал Хангайн бүсэд 101, Төвийн бүсэд 121, Улаанбаатарт 18, Баруун бүсэд 264, Зүүн бүсэд 62 тус бүр цолтой уяач бүртгэгдсэн байна.



ГРАФИК 19. Цолтой уяач, бүсээр



Өмнөх онтой харьцуулахад цолтой уяачдын тоо даруй 124 уяачаар өссөн байна.

ЗУРАГ 11. Цолтой уяач, аймаг, нийслэлээр






3.6. Хурдан морь унаач хүүхэд



Монгол Улсад 2025 оны байдлаар нийт 21753 хурдан морь унаач хүүхэд бүртгэгдсэнийг бүсээр авч үзвэл, Хангайн бүсэд 5394, Төвийн бүсэд 3867, Баруун бүсэд 6645, Зүүн бүсэд 5376, нийслэлд 471 унаач хүүхэд бүртгэгдсэн байна. Өмнөх онтой харьцуулахад хурдан унаач хүүхдийн тоо энэ онд 1195 хүүхдээр буурсан байна.


ГРАФИК 20. Хурдан морь унаач хүүхэд, бүсээр



Аймаг нийслэлээр авч үзвэл, Дорнод аймагт хурдан морь унаач 3864 хүүхэд, Ховд аймагт 2600, Хөвсгөл аймагт 2050, Говь-Алтай аймагт 1850, Сэлэнгэ аймагт 1254, Сүхбаатар аймагт 1200 хүүхэд бүртгэгдсэн нь хамгийн олон хурдан морь унаач хүүхэд бүртгэгдсэн аймгууд байна. Бусад аймгуудын хувьд 200-1000 хурдан морь унаач хүүхэд бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 12. Хурдан морь унаач хүүхэд, аймаг, нийслэлээр






4. БИЕ БЯЛДРЫН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛД ХАМРАГДАГЧИД

Бие бялдрын түвшин тогтоох сорилд 2025 онд нийт 142226 иргэн хамрагдсан бөгөөд тэдгээрийн 71477 (50.3%) нь эрэгтэй, 70749 (49.7%) нь эмэгтэй байна. Сорилд хамрагдагчдыг өмнөх онтой харьцуулахад нийт дүнгээр 158599 оролцогчоор буурсан байна.


“Ковид-19” цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж тухайн жилүүдэд бие бялдрын түвшин тогтоох сорил зохион байгуулах давтамж болон хамрагдсан оролцогчдын тоо буурч байсан бол 2022 оноос эхлэн нөхцөл байдал сэргэж биеийн тамир, спортын арга хэмжээг урьдын адил зохион байгуулж, бие бялдрын түвшин тогтоох сорилд олон нийтийг идэвхтэй хамруулсан байна.

ГРАФИК 21. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэд





Нийслэл Улаанбаатар болон Зүүн бүсэд 2020 онд сорил авах үйл ажиллагаа зохион байгуулаагүй бол 2021 онд мөн адил Зүүн болон Баруун бүсэд сорил авах үйл ажиллагаа зохион байгуулаагүй. 2022 оноос бүх засаг захиргааны нэгжид сорил авах үйл ажиллагаа зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2025 онд Улаанбаатар хотод зохион байгуулсан сорилд нийт 46106 (32.4%), Төвийн бүсэд 36088 (25.4%), Хангайн бүсэд 27676 (19.5%), Зүүн бүсэд 8881 (6.2%), Баруун бүсэд 23475 (15.5%) иргэн сорилд хамрагдсан байна.


ГРАФИК 22. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэд, бүсээр



Сорилд хамрагдсан иргэдийг аймаг, нийслэлээр авч үзвэл, нийслэлээс гадна Дархан-Уул аймагт 8012 (5.6%), Хөвсгөл аймагт 7387 (5.2%), Сэлэнгэ аймагт 7060 (5.0%), Төв аймагт 6311 (4.4%) иргэн сорилд хамрагдсан байна.


ЗУРАГ 13. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэд, аймаг, нийслэлээр






Хүйсийн тэнцвэрт байдлыг аймаг, нийслэлээр авч үзвэл, ихэнх аймгийн хувьд ойролцоо тооны эрэгтэй, эмэгтэй хамрагдсан байна.

ГРАФИК 23. Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэд, хүйсээр, аймаг, нийслэлээр




Бие бялдрын түвшин тогтоох сорилын үнэлгээг улсын хэмжээнд авч үзвэл, “А” үнэлгээ 21.1%, “В” үнэлгээ 29.4%, “С” үнэлгээ 20.3%, “D” үнэлгээ 17.7% , “F” үнэлгээ 11.5% байна. Өмнөх онтой харьцуулахад үнэлгээний хувь “А”- 0.1, “В”- 1.1, “С”- 3.0 функтээр тус бүр буурсан бол, “D”- 3.5 “F”- 0.7 функтээр тус тус өссөн байна.

ГРАФИК 24. Бие бялдрын түвшин тогтоох сорил, үнэлгээний ангиллаар



Улсын хэмжээнд “А” үнэлгээний 30.8%, “В” үнэлгээний 33.6%, “С” үнэлгээний 47.8%, “D” үнэлгээний 19.5%, “F” үнэлгээтэй 24.9%-ийг Улаанбаатар эзэлж байна. Харин Зүүн бүсийн хувьд үнэлгээний дүнгийн бүх ангиллын хамгийн бага хувийг эзэлж байна. Тодруулбал, “А” үнэлгээний 5.8%, “В” үнэлгээний 6.2%, “С” үнэлгээний 5.5%, “D” үнэлгээний 8.4%, “F” үнэлгээтэй 5.0%-ийг эзэлж байгаа нь бусад аймгуудын хамрагдсан иргэдийн тооноос бага байгаатай холбоотой юм.

ГРАФИК 25. Бие бялдрын түвшин тогтоох сорил, үнэлгээний ангиллаар, бүсээр



Бүсийн үнэлгээг задлан харвал, Баруун бүсэд D, Төвийн бүсэд B, Хангайн бүсэд B, Зүүн бүсэд B үнэлгээ нь бусад үнэлгээтэй харьцуулахад өндөр хувийг эзэлж байна.


2025	Нийт хамрагдагчдын улсын дүнд эзлэх хувь	Үнэлгээний ангилал, дүнд эзлэх хувиар					Үнэлгээний ангилал - Бүгд дүн
		A	B	C	D	F	
Баруун	16.5%	22.3%	25.5%	10.0%	28.8%	13.4%	100.0%
Хангайн	19.5%	27.3%	34.8%	11.8%	11.3%	14.9%	100.0%
Төвийн	25.4%	17.4%	26.4%	21.7%	22.8%	11.7%	100.0%
Зүүн	6.2%	19.6%	29.4%	18.0%	23.8%	9.3%	100.0%
Улаанбаатар	32.4%	20.1%	30.5%	29.9%	10.6%	8.9%	100.0%
Бүгд дүн	100.0%	-	-	-	-	-	

2024	Нийт хамрагдагчдын улсын дүнд эзлэх хувь	Үнэлгээний ангилал, дүнд эзлэх хувиар					Үнэлгээний ангилал - Бүгд дүн
		A	B	C	D	F	
Баруун	4.6%	21.4%	32.6%	21.4%	12.5%	12.1%	100.0%
Хангайн	25.1%	21.7%	32.3%	25.1%	10.8%	10.1%	100.0%
Төвийн	31.2%	21.9%	27.8%	23.9%	15.5%	11.0%	100.0%
Зүүн	5.5%	19.1%	22.6%	25.0%	19.5%	13.8%	100.0%
Улаанбаатар	33.6%	20.7%	32.6%	21.3%	14.9%	10.5%	100.0%
Бүгд дүн	100.0%	-	-	-	-	-	

2023	Нийт хамрагдагчдын улсын дүнд эзлэх хувь	Үнэлгээний ангилал, дүнд эзлэх хувиар					Үнэлгээний ангилал - Бүгд дүн
		A	B	C	D	F	
Баруун	3.3%	17.0%	18.8%	20.7%	23.7%	19.7%	100.0%
Хангайн	17.3%	23.3%	34.6%	26.8%	11.0%	4.3%	100.0%
Төвийн	22.3%	20.3%	27.0%	24.1%	20.5%	8.1%	100.0%
Зүүн	2.6%	22.2%	27.4%	20.5%	13.5%	16.4%	100.0%
Улаанбаатар	54.5%	24.3%	33.7%	22.7%	13.3%	6.0%	100.0%
Бүгд дүн	100.0%	-	-	-	-	-	

Бие бялдрын түвшин тогтоох сорилын дүнгээр нийт хамрагдагчдын 22774 (16.0%) нь илүүдэл жинтэй байгаагийн 13279 (58.3%) нь эмэгтэй, 9495 (41.7%) нь эрэгтэй байна.


ГРАФИК 26. Бие бялдрын түвшин тогтоох сорил, үнэлгээний дүн, хүйсээр



5. СПОРТЫН ТАМИРЧИД


Монгол Улсад 2025 онд нийт 177914 тамирчин бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулбал 14.6%-иар өссөн үзүүлэлттэй байна. Үүнийг бүсээр авч үзвэл, Хангайн бүсэд 47103 (26.5%) нь, Төвийн бүсэд 31282 (17.6%) нь, Баруун бүсэд 22062 (12.4%) нь, Зүүн бүсэд 14220 (8.0%) байгаа бол Улаанбаатарт 63247 (35.5%) нь байна.

ГРАФИК 27. Тамирчид, бүсээр




Нийт тамирчдын дийлэнх хувийг буюу 75262 (42.3%) нь спорт тоглоом, 26272 (14.8%) нь үндэсний спорт, 26490 (14.9%) нь халз тулаан, хүчний спорт, 18182 (10.2%) оюуны спорт, 27457 (15.4%) хэмжигдэхүүнтэй спорт үлдсэн 4251 (2.4%) нь пара болон цэрэгжлийн спортын тамирчид эзэлж байна.

ГРАФИК 28. Тамирчид, спортын хураангуй төрлөөр




Спортын төрлийг бүсээр авч үзвэл, спорт тоглоомын төрөл бүх бүсэд давамгайлж байна. Тодруулбал, Хангайн бүсэд 19028, Баруун бүсэд 10461, Төвийн бүсэд 12503, Зүүн бүсэд 6078, Улаанбаатарт 27192 тамирчин энэ төрөлд бүртгэгдсэн байна.

ГРАФИК 29. Тамирчид, спортын төрлөөр, бүсээр



Нийт тамирчдын тоог аймаг, нийслэлээр авч үзвэл Хөвсгөл, Төв болон Улаанбаатар хотод хамгийн олон тамирчинтай бол Говьсүмбэр, Завхан, Дархан-Уул, Говь-Алтай аймгуудад бусад аймгуудтай харьцуулаад цөөн тооны тамирчин бүртгэгдсэн байна.


ЗУРАГ 13. Тамирчид, аймаг, нийслэлээр



6. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ


2019 оноос хойш зохион байгуулсан спортын арга хэмжээ даруй буурсан нь “Ковид-19” цар тахал дэгдэж Монгол Улсын засгийн газар, УОК-ын шийдвэрээр удаа дараагийн хөл хорио тогтоосонтой холбоотой бөгөөд 2024 онд 4122 арга хэмжээ зохион байгуулсан бол 2025 онд 4276 арга хэмжээ зохион байгуулсан байна.

ГРАФИК 30. Биеийн тамир, спортын арга хэмжээ




2025 онд зохион байгуулсан спортын арга хэмжээг бүсээр авч үзвэл Хангай болон Төвийн бүсэд хамгийн олон зохион байгуулсан байна. Тодруулбал, Хангайн бүсэд 1149 (26.9%), Төвийн бүсэд 1472 (34.4%), Баруун бүсэд 724 (16.9%), Зүүн бүсэд 377 (8.8%), Улаанбаатарт 554 (13.0%) арга хэмжээ зохион байгуулсан байна.

ГРАФИК 31. Биеийн тамир, спортын арга хэмжээ, бүсээр




Нийт зохион байгуулсан нийт арга хэмжээний 2283 (53.4%) нь сумын, 1784 (41.7%) нь аймаг, нийслэлийн чанартай арга хэмжээ байна.

ГРАФИК 32. Биеийн тамир, спортын арга хэмжээ, чанараар




Зохион байгуулагдсан арга хэмжээг чанараар нь авч үзвэл, нийт зохион байгуулсан олон улсын чанартай тэмцээний 66.7%, улсын чанартай арга хэмжээний 35.8% нь нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулсан байна. Харин бүсийн чанартай арга хэмжээний 41.0%, аймаг нийслэлийн чанартай тэмцээний 52.8% нь тус бүр Төвийн бүсэд зохион байгуулсан бол сум дүүргийн чанартай тэмцээний 30.4% нь Хангайн бүсэд зохион байгуулагдсан байна.

ГРАФИК 33. Биеийн тамир, спортын арга хэмжээ, чанараар, бүсээр





ЗУРАГ 13. Биеийн тамир, спортын арга хэмжээ, аймаг, нийслэлээр, 2025




Аймаг, нийслэлийн чанартай арга хэмжээг Дундговь, Өвөрхангай, Төв болон Сэлэнгэ аймгуудад, харин сум, дүүргийн чанартай арга хэмжээг Дундговь, Өвөрхангай, Төв, Увс, Ховд, Хэнтий, Орхон болон нийслэлд хамгийн олон тоогоор зохион байгуулсан байна.

ЗУРАГ 14. Биеийн тамир, спортын арга хэмжээ, чанараар









7. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОГЧИД

Зохион байгуулсан спортын арга хэмжээнд нийт 1629741 оролцогч хамрагдсан бөгөөд эдгээрийн 357029 (21.9%) нь Хангайн бүсэд, 203860 (12.5%) нь Төвийн бүсэд, 133132 (8.2%) нь Баруун бүсэд, 60709 (3.7%) нь Зүүн бүсэд, 875011 (53.7%) нь Улаанбаатарт хамрагдсан байна. Нийт оролцогчдын тоог өмнөх онтой харьцуулахад 303779 оролцогчдоор буюу 22.9% нэмэгдсэн байна.

ГРАФИК 34. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч






ГРАФИК 35. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, бүсээр




Нийт оролцогчдын 559891 (34.4%) нь сум, дүүргийн чанартай, 975141 (59.8%) нь аймаг, нийслэлийн чанартай арга хэмжээнд оролцсон байна.

ГРАФИК 36. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, арга хэмжээний чанараар



Оролцогчдыг бүсийн харьяаллаар авч үзвэл, Олон улсын чанартай арга хэмжээнд оролцогчдын 91.1% нь нийслэлийн, улсын чанартай арга хэмжээнд оролцогчдын 50.2% нь, бүсийн чанартай арга хэмжээний 29.7% нь Хангайн бүсийн, аймаг, нийслэлийн чанартай арга хэмжээний 61.6% нь, сум, дүүргийн чанартай арга хэмжээнд оролцогчдын 42.4% нь Улаанбаатарын оролцогчид байна.

ГРАФИК 37. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, арга хэмжээний чанараар, бүсээр




2025	Улсын дүнд эзлэх хувь	Чанар, дүнд эзлэх хувиар					Чанар - Бүгд дүн
		Олон улсын	Улсын	Бүсийн	Аймаг, нийслэлийн	Сум, дүүргийн	
Баруун	8.2%	0.0%	3.7%	5.5%	34.2%	56.7%	100.0%
Хангайн	21.9%	0.2%	5.0%	1.8%	44.1%	48.9%	100.0%
Төвийн	12.5%	1.3%	3.1%	2.5%	68.2%	25.0%	100.0%
Зүүн	3.7%	0.2%	5.8%	5.5%	53.4%	35.1%	100.0%
Улаанбаатар	53.7%	3.8%	0.3%	0.0%	68.7%	27.1%	100.0%
Бүгд дүн	100.0%	-	-	-	-	-	-


2024 он	Улсын дүнд эзлэх хувь	Чанар, дүнд эзлэх хувиар					Чанар - Бүгд дүн
		Олон улсын	Улсын	Бүсийн	Аймаг, нийслэлийн	Сум, дүүргийн	
Баруун	7.0%	0.0%	1.2%	2.7%	44.0%	52.1%	100.0%
Хангайн	24.7%	6.3%	2.6%	1.6%	44.8%	44.8%	100.0%
Төвийн	17.0%	0.5%	3.8%	1.9%	65.4%	28.5%	100.0%
Зүүн	3.4%	0.0%	9.3%	8.8%	61.6%	20.3%	100.0%
Улаанбаатар	48.0%	5.1%	0.7%	0.2%	57.0%	37.0%	100.0%
Бүгд дүн	100.0%	-	-	-	-	-	-

2023 он	Улсын дүнд эзлэх хувь	Чанар, дүнд эзлэх хувиар					Чанар - Бүгд дүн
		Олон улсын	Улсын	Бүсийн	Аймаг, нийслэлийн	Сум, дүүргийн	
Баруун	11.3%	0.3%	1.0%	2.5%	27.9%	68.3%	100.0%
Хангайн	20.1%	0.2%	3.5%	1.8%	47.9%	46.6%	100.0%
Төвийн	18.0%	0.3%	4.5%	1.7%	65.1%	28.6%	100.0%
Зүүн	4.1%	0.4%	5.3%	5.8%	34.9%	53.7%	100.0%
Улаанбаатар	46.5%	4.2%	20.5%	0.0%	4.7%	70.6%	100.0%
Бүгд дүн	100.0%	-	-	-	-	-	-

Зохион байгуулсан спортын арга хэмжээнд Улаанбаатар, Орхон, Өвөрхангай, Архангай болон Увс аймгуудаас хамгийн олон тооны оролцогчид хамрагдсан бол Сүхбаатар, Говь-Алтай болон Говьсүмбэр аймгуудад бусад аймгуудтай харьцуулахад цөөн тооны оролцогчид оролцсон гэж бүртгэгдсэн байна.



ЗУРАГ 15. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, аймаг, нийслэлээр






Аймаг, нийслэл чанартай арга хэмжээнд оролцогчдын тоогоор Улаанбаатар, Архангай, Баянхонгор болон Төв аймгууд, харин сум, дүүргийн чанартай арга хэмжээнд оролцогчдын тоогоор Улаанбаатар болон Орхон, Увс аймгууд тэргүүлж байна.

ЗУРАГ 16. Биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцогч, чанараар





ХАВСРАЛТ

Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/Г04 тоот тушаалаар батлав.

А-БТС-1

БИЕЙН ТАМИР, СПОРТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧИДЫН 2025 ОНЫ МЭДЭЭ

Биеийн тамир, спортын агууламд ажилласан төрийн захиргааны төв байгууллагад ухувчлалын эзсийн мэдээг дараа оны 2-р сарын 15-ны өдөр Мэдээний статистикийн хороонд шалхи шуудан болон цагаар ирүүлнэ.

Бус, аймгаар, нийслэл	МД	Биеийн тамир, спортын байгууллага	Ажиллагчид-Бүгд	Эмэгтэй	Удирдах ажилтан	Захирагаа, санхүүгийн ажилтан	Мэргэжилтэн	Дасгалжуулагч	Албан тушаалаар				Хөдөлмөрийн бэрхшээлтэй	Эмэгтэй
									Эмч	Бусад	Үйлчилгээ, аж ахуйн ажилтан	Биеийн тамирын арга зүйч		
Бүгд мөр1=мөр(2+8+15+23+27)	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Баруун бүс мөр2=мөр(3:7)	1	35	900	398	56	101	162	151	80	18	302	30	33	16
Баян-Өлгий	3	1	29	6	3	2	5	6	4	0	8	1	0	0
Говь-Алтай	4	1	15	4	1	2	1	0	5	0	6	0	0	0
Завхан	5	1	22	7	1	5	3	5	3	0	7	0	0	7
Увс	6	1	29	9	2	3	3	3	2	0	9	7	1	1
Хөвд	7	1	26	13	2	2	5	8	1	0	8	0	2	1
Хангайн бүс мөр8=мөр(8:14)	8	7	191	70	11	18	29	30	17	2	75	9	5	1
Архангай	9	1	41	12	3	4	7	9	4	0	14	0	2	0
Баянхонгор	10	1	33	12	1	2	4	9	2	1	12	2	1	0
Булган	11	1	23	10	3	3	1	2	3	1	10	0	0	0
Орхон	12	1	26	13	1	4	1	0	0	10	10	0	2	1
Өвөрхангай	13	2	34	13	2	6	6	3	4	0	15	0	0	0
Хөвсгөл	14	1	34	10	1	1	0	7	4	0	14	7	0	0
Төвийн бүс мөр15=мөр(16:22)	15	8	222	112	7	16	24	52	31	3	80	9	11	3
Говьсүмбэр	16	1	23	10	1	2	9	2	1	1	7	0	3	1
Дархан-Уул	17	1	28	10	2	2	3	9	3	0	8	1	3	0
Дорноговь	18	1	42	30	1	4	0	17	7	0	10	3	5	2
Дундговь	19	1	15	6	0	2	3	4	1	0	5	0	0	0
Өмнөговь	20	1	24	13	1	3	1	9	1	1	7	1	0	0
Сэлэнгэ	21	2	65	32	1	1	5	7	13	1	33	4	0	0
Төв	22	1	25	11	1	2	3	4	5	0	10	0	0	0
Зүүн бүс мөр23=мөр(24:26)	23	3	103	43	4	8	10	32	4	1	42	2	7	2
Дорнод	24	1	21	7	1	5	4	7	1	0	7	0	0	0
Сүхбаатар	25	1	43	23	2	2	4	10	1	1	23	0	4	1
Хэнтий	26	1	39	13	1	1	6	15	2	0	12	2	3	1
Улаанбаатар	27	12	263	134	25	45	84	15	13	12	67	2	7	1
Баянхүүр	1	1	23	12	3	4	8	0	0	0	8	0	0	0
Багахангай	1	1	17	12	1	4	6	0	0	0	6	0	2	0
Баянгол	1	1	25	13	1	2	11	2	0	0	8	1	0	0
Баянзүрх	1	1	13	5	1	5	7	0	0	0	0	0	0	0
Налайх	1	1	25	15	1	3	10	0	0	0	11	0	0	0
Чингэлтэй	1	1	25	9	1	4	0	6	4	0	10	0	1	0
Сонгинохайрхан	1	1	13	7	1	2	5	2	3	0	0	0	0	0
Сүхбаатар	1	1	22	12	3	4	4	4	4	0	7	0	0	0
Хан-Уул	1	1	27	12	5	5	0	1	2	1	13	0	4	1
Нийслэлийн Биеийн тамир, спортын га	1	12	7	0	2	0	8	0	0	0	2	0	0	0
ЗТГА-Биеийн тамир, спортын улсын хо	1	35	18	5	4	4	25	0	0	0	0	1	0	0
БТСУХ-ны харьяа Спортын аялагдах ур	1	26	12	1	8	4	4	0	0	11	2	0	0	0

Хянасан: Болдогтөвлөвлөлийн газрын дарга О.Гэрэл (Овог, нэр) (Гарын үсэг)

Мэдээ гаргасан: Малсажигдан Б.Ганзориг (Овог, нэр) (Гарын үсэг)

Тамга Тэмдэг

2026 оны 02 сарын 14 өдөр

Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/104 тоот тушаалаар батлав.

ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРСОН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН 2025 ОНЫ МЭДЭЭ

Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн эцсийн мэдээг дараа оны 2-р сарын 15-ны дотор Үндэсний статистикийн хороонд цахим шуудан болон маяггаар ирүүлнэ.

Бус, аймаг, нийслэл	МД	Бүгд	Төрлөөр				
			Спортын ордон	Спортын заал	Балтгалийн заал	Усан бассейн	Бусад
А	Б	1	2	3	4	5	6
Бүгд мөр1=мөр(2+8+15+23+27)	1	43	3	30	5	2	3
Баруун бүс мөр2=мөр(3.7)	2	11	0	11	0	0	0
Баян-Өлгий	3	1	0	1	0	0	0
Говь-Алтай	4	3	0	3	0	0	0
Завхан	5	2	0	2	0	0	0
Увс	6	0	0	0	0	0	0
Ховд	7	5	0	5	0	0	0
Хангайн бүс мөр8=мөр(9.14)	8	10	0	10	0	0	0
Архангай	9	2	0	2	0	0	0
Баянхонгор	10	3	0	3	0	0	0
Булган	11	0	0	0	0	0	0
Орхон	12	2	0	2	0	0	0
Өвөрхангай	13	1	0	1	0	0	0
Хөвсгөл	14	2	0	2	0	0	0
Төвийн бүс мөр15=мөр(16.22)	15	10	1	6	0	0	3
Говьсүмбэр	16	1	0	1	0	0	0
Дархан-Уул	17	4	0	1	0	0	3
Дорноговь	18	1	1	0	0	0	0
Дундговь	19	0	0	0	0	0	0
Өмнөговь	20	0	0	0	0	0	0
Сэлэнгэ	21	2	0	2	0	0	0
Төв	22	2	0	2	0	0	0
Зүүн бүс мөр23=мөр(24.26)	23	6	1	0	4	1	0
Дорнод	24	6	1	0	4	1	0
Сүхбаатар	25	0	0	0	0	0	0
Хэнтий	26	0	0	0	0	0	0
Улаанбаатар	27	6	1	3	1	1	0
Баянзүрх	28	0	0	0	0	0	0
Баянхонгор	29	1	1	0	0	0	0
Баянгол	30	0	0	0	0	0	0
Баянзүрх	31	0	0	0	0	0	0
Налайх	32	0	0	0	0	0	0
Цингэлтэй	33	1	0	0	0	1	0
Сонгинохайрхан	34	0	0	0	0	0	0
Сүхбаатар	35	2	0	2	0	0	0
Хан-Уул	36	2	0	1	1	0	0

Балансын шалгалт: багана 1=багана(2.6)

А-БТС-2-ын үргэлжлэл

Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/104 тоот тушаалаар батлав.

2. ГАДАА ТАЛБАЙ

Бүс, аймаг, нийслэл	МД	Бүгд	Төрлөөр							Цанын бааз	Бусад
			Цэнгэлдэх хүрээлэн	Наадмын талбай	Спортын гадаа талбай	Явган алхалт, аяллын зам	Дугуйн зам	Гүйлтийн зам			
А											
Бүгд мөр1=мөр(2+8+15+23+27)	Б	84	0	4	64	5	4	4	1	2	
Баруун бүс мөр2=мөр(3:7)	1	19	0	2	16	1	0	0	0	0	
Баян-Өлгий	3	3	0	0	3	0	0	0	0	0	
Говь-Алтай	4	7	0	1	6	0	0	0	0	0	
Увс	5	6	0	1	5	0	0	0	0	0	
Завхан	6	3	0	0	2	1	0	0	0	0	
Ховд	7	0	0	0	0	0	0	0	0	0	
Хангайн бүс мөр8=мөр(9:14)	8	16	0	0	14	1	1	0	0	0	
Архангай	9	0	0	0	0	0	0	0	0	0	
Баянхонгор	10	3	0	0	3	0	0	0	0	0	
Булган	11	0	0	0	0	0	0	0	0	0	
Орхон	12	6	0	0	5	0	1	0	0	0	
Өвөрхангай	13	6	0	0	6	0	0	0	0	0	
Хөвсгөл	14	1	0	0	0	1	0	0	0	0	
Төвийн бүс мөр15=мөр(16:22)	15	23	0	1	20	1	1	0	0	0	
Говьсүмбэр	16	1	0	0	1	0	0	0	0	0	
Дархан-Уул	17	6	0	1	4	1	0	0	0	0	
Дорноговь	18	6	0	0	6	0	0	0	0	0	
Дундговь	19	1	0	0	1	0	0	0	0	0	
Өмнөговь	20	4	0	0	3	0	1	0	0	0	
Сэлэнгэ	21	3	0	0	3	0	0	0	0	0	
Төв	22	2	0	0	2	0	0	0	0	0	
Зүүн бүс мөр23=мөр(24:26)	23	11	0	1	9	1	0	0	0	0	
Дорнод	24	7	0	1	5	1	0	0	0	0	
Сүхбаатар	25	4	0	0	4	0	0	0	0	0	
Хэнтий	26	0	0	0	0	0	0	0	0	0	
Улаанбаатар	27	15	0	0	5	1	2	4	1	2	

Балансын шалгалт: багана1=багана(2:9)

Хянасан: Бодлого төлөвлөлтийн газрын дарга _____ О.Гэрэл
 (Албан тушаал) (Овог, нэр)
 Мөдээ гаргасан: мөргэжилтэн _____ Б.Ганзориг
 (Албан тушаал) (Овог, нэр)

2026 оны 02 сарын 14 өдөр

Ундасний статистикийн хорооны даргын 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/104 тоот тушаалыг баллав.

А-БТС-3

ЦОЛТОЙ ТАМИРЧИД, ШҮҮГЧДИЙН 2025 ОНЫ МЭДЭЭ

Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн эцсийн мэдээг дараах оны 2-р сарын 15-ны дотор Ундасний статистикийн хороонд цахим шүүдэн болон маягаар ирүүлнэ.

Бүс, аймаг, нийслэл	МД	Цолтой тамирчид			Цолтой бөхчүүд					Цолтой урванд	Хурдны морь унаач хүүхэд	Цолтой шүүгчид	Эмэгтэй	Олон улсын шүүгч	
		Эмэгтэй	Олон улсын мастер	Спортын мастер	Спортын дэд мастер	Бүгд	Улсын	Аймаг/цэргийн	Сумын						Цолтой сурвч харваачид
А	Б	1	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
Бүгд мөр1=мөр(2+8+15+23+27)	1	2229	457	550	696	619	111	116	492	161	566	21753	93	26	18
Баруун бүс мөр2=мөр(3:7)	2	395	62	7	68	217	2	30	185	44	264	6645	2	0	0
Баян-Өлгий	3	40	9	10	5	17	0	4	13	5	22	935	2	0	0
Говь-Алтай	4	104	17	4	25	32	2	6	23	12	225	1850	0	0	0
Завхан	5	69	4	0	9	46	0	6	40	9	15	600	0	0	0
Увс	6	66	1	3	7	53	0	9	44	3	0	660	0	0	0
Ховд	7	116	31	12	19	70	0	5	65	15	2	2600	0	0	0
Хангайн бүс мөр8=мөр(9:14)	8	614	141	129	231	162	3	23	136	34	101	5394	22	7	1
Архангай	9	75	4	10	20	37	1	4	32	5	10	537	4	2	1
Баянхонгор	10	51	10	5	19	22	1	3	18	4	17	1011	0	0	0
Булган	11	61	9	2	22	21	0	3	18	3	44	900	0	0	0
Орхон	12	332	112	49	150	37	0	5	32	18	21	96	14	2	0
Өвөрхангай	13	53	0	2	10	17	1	5	15	3	1	800	3	2	0
Хөвсгөл	14	42	6	1	13	24	1	3	21	1	8	2050	1	1	0
Төвийн бүс мөр15=мөр(16:22)	15	301	46	55	84	96	4	19	73	40	121	3867	9	2	2
Говьсүмбэр	16	46	12	11	20	2	0	0	2	3	3	200	3	0	0
Дархан-Уул	17	39	9	1	10	12	11	0	3	8	5	120	4	1	0
Дорноговь	18	58	1	8	4	23	3	4	16	16	12	300	1	0	1
Дундговь	19	48	11	10	22	17	0	5	2	4	26	630	0	0	0
Өмнөговь	20	41	4	7	15	17	0	2	15	0	32	350	0	0	0
Сэлэнгэ	21	33	3	1	5	18	1	2	15	9	11	1254	0	0	0
Төв	22	36	6	0	11	18	0	3	15	3	32	1013	1	1	1
Зүүн бүс мөр23=мөр(24:26)	23	187	31	14	48	47	2	5	40	36	62	5376	8	1	2
Дорнод	24	87	16	28	25	15	0	1	14	7	32	3864	4	1	0
Сүхбаатар	25	39	5	5	11	15	1	2	12	8	10	1200	0	0	0
Хэнтий	26	61	10	2	15	17	1	2	14	21	20	312	4	0	2
Улаанбаатар	27	732	177	259	271	97	0	39	58	7	18	471	52	16	13
Баянүр	28	24	0	4	8	2	0	2	0	2	0	0	0	0	0
Багахангай	29	24	3	15	4	5	0	0	5	0	17	72	2	0	0
Баянгол	30	77	17	30	30	0	0	0	0	0	0	0	4	2	0
